



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 01 сарын 20 өдөр


Дугаар 8/24

Улаанбаатар хот

Бүх нийтийн бэлэн байдлын
зэргийг сунгах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын тархалтын үед эрүүл мэндийн салбарыг бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс халдвартын тархалт зогсох хүртэл үргэлжлүүлэн сунгасугай.
2. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын тархалтын үед эмнэлгийн тусlamж үзүүлэх зураглалыг хавсралтаар баталсугай.
3. Тушаалын хэрэгжилтийг хангаж, тогтмол хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирлуудад үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Төрийн захирагааны удирлагын газар /П.Эрхэмбулган/, Эмнэлгийн тусlamжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар /Я.Буянжаргал/, Нийтийн эрүүл мэндийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар /Р.Гантуяа/-т, хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар /Д.Ганцэцэг/-т тус тус даалгасугай.



141210014

Эрүүл мэндийн сайдын 2021 оны
01 дүгээр сарын 25-ний өдрийн
Я/24 дугаар тушаалын хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ТАРХАЛТЫН ҮЕД ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ ЗУРАГЛАЛ

1. Эмнэлгийн яаралтай тусlamжийн тасаг/нэгжээр үйлчлүүлэгчид хийх халдвaryн илрүүлгийн зураглal

- 1.1. Яаралтай тусlamжийн тасаг/нэгжийн хүлээлгийн танхимд хүн хоорондын зайд бариулах, тэмдэг, тэмдэглэгээ тавьж, хөтөч ажиллуулах;
- 1.2. Яаралтай тусlamжаар үйлчлүүлсэн иргэн бүрийг байгууллагын QR кодыг уншуулах, бүртгэлжүүлэх;
- 1.3. Яаралтай тусlamжаар үйлчлүүлэх гэж байгаа иргэнийг ар гэрийг хүлээн авах танхимд байлгахгүй;
- 1.4. Өндөр настан болон насанд хүрээгүй хүүхдийг зөвхөн нэг хүн дагах /2-оос илүү хүн дагаж орохгүй байх/;
- 1.5. Үйлчлүүлж байгаа иргэний хувцасыг нэг дор өлгөхгүй, хүлээлгийн танхимд ил байлгахгүй, аль болох тус тусад нь уутанд хийлгэх;
- 1.6. Яаралтай тусlamжийн тасгийн эрэмбэлэн ангилах хэсгээс тусад нь хүлээлгийн танхимын ойролцоо түргэвчилсэн оношилгоо болон PCR шинжилгээний сорьц авах өрөө байгуулж, халдвaryн сэргийлэлтийн дэглэм мөрдөн шинжилгээг хийх;
- 1.7. Яаралтай тусlamжийн тасаг/нэгжээр үйлчлүүлэхээр ирсэн иргэн бүрийг коронавируст халдвaryг илрүүлэх түргэвчилсэн оношлуураар шинжилнэ;
- 1.8. Түргэвчилсэн оношилгооны шинжилгээний хариу эргэлзээтэй гарсан хүн бүрийг тусгаарлах өрөөнд PCR шинжилгээний хариу гартал тусгаарлан ажиглана;
- 1.9. Тусгаарлалтад авсан иргэнтэй хамт яваа иргэнд түргэвчилсэн оношилгоо хийх, шинжилгээний хариунаас шалтгаалан хариу арга хэмжээг авна;
- 1.10. Халдвар хамгааллын дэглэмийг баримтлан тусгаарлан ажиглалтад байгаа иргэний биеийн байдалд хяналт тавьж, шаардлагатай эмчилгээг хийнэ;
- 1.11. Нийслэл хотод байрлалтай эрүүл мэндийн байгууллагуудад тусгаарлагдсан иргэний PCR шинжилгээний сорьцон дээр "Яаралтай" тэмдэглэгээ тавьж, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Бэлгийн замаар дамжих халдвaryн лабораториид шуурхай хүргүүлнэ;
- 1.12. Шинжилгээний хариу гартал асуумж, шинжилгээ авсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь эмнэлгийн бусад ажилтнуудтай хавьталь болохгүй байх.

2. Амбулаториор үйлчлүүлэгчид хийх халдвaryн сэргийлэлтийн арга хэмжээний зураглal

- 2.1. Амбулаториор аль болох цаг авсан иргэнд үйлчлэх;

- 2.2. Ирсэн үйлчлүүлэгч бүрээс тархвар зүйн асуумж авч, тандалт хийнэ;
- 2.3. Үйлчлүүлэгчийн тандалтыг хийхдээ хүлээгдэл, бөөгнөрөл үүсгэхгүй, нэг үйлчлүүлэгчтэй 15 минутаас дээш хугацаанд харьцаахгүй байхаар зохион байгуулна;
- 2.4. Үйлчлүүлэгчдийн гадуур хувцсыг хооронд нь шүргэлцэхгүйгээр өлгөх, ажиллаж байгаа үйлчилгээний ажилтан зохих хамгаалах хувцас хэрэгслийг бүрэн өмссөн байна;
- 2.5. Амьсгалын замын өвчин/эмгэгийн үзлэгийн кабинетыг амбулаторийн бусад кабинет, тасаг, нэгжээс тусад нь эмнэлгийн орох, гарах хаалгын ойролцоо байхаар зохион байгуулна;
- 2.6. Амьсгалын замын өвчин/эмгэгийн шинж тэмдэгтэй иргэнийг бусад үйлчлүүлэгчтэй удаан хамт байлгахгүй шуурхай чиглүүлж, үзлэгт хамруулна;
- 2.7. Амьсгалын замын эмгэгийн улмаас хандсан үйлчлүүлэгч бүрээс коронавируст халдвартыг илрүүлэх түргэвчилсэн оношилгоонд хамруулж, сэжигтэй тохиолдлыг тусгаарлан ажиглалтад авч, PCR шинжилгээнд сорьцыг "Яаралтай" тэмдэглэгээ тавьж, нийслэлд Халдварт өвчин судалын үндэсний төвийн Бэлгийн замаар дамжих халдвартын лабораториид, аймгийн эрүүл мэндийн байгууллагууд PCR шинжилгээ хийж байгаа харьяа нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төв, лавлагаа төвд хуваарийн дагуу шуурхай хүргэнэ;
- 2.8. Амбулаториид 2 цаг тутамд ээлжээр ажиллаж хяналт тавих эмч, эмнэлгийн мэргэжилтнийг томилж хуваарь гарган баталгаажуулна;
- 2.9. Амбулаторийн хүлээлгийн танхимд хүн хоорондын зайд, амны хаалтын хэрэглээнд болон эмнэлзүйн шинж тэмдгийн хяналтыг тогтмол хийнэ;
- 2.10. Эмнэлгийн үйлчлүүлэгчдэд халдвартын сэргийлэлтийн талаар мэдээлэл, анхааруулгыг чанга яригчаар тогтмол мэдээлнэ;
- 2.11. Үйлчлүүлэгчийн ариун цэврийн өрөөний агаарын сэлгэлтийг сайжруулах, тогтмол нээлттэй байлгах, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмолжуулж, гар угаах, ариутгах нөхцөлийг бүрдүүлнэ;
- 2.12. Амбулаторийн эмч, үйлчлүүлэгчтэй харьцах хугацаанд амны хаалтыг зөв зүүж, бээлий өмсөх ба үйлчлүүлэгч амны хаалтаа зөв зүүсэн эсэхэд хяналт тавина;
- 2.13. Үйлчлүүлэгч үзлэгийн өрөөнд орохын өмнө, эмнэлгийн мэргэжилтэн үзлэг, үйлчилгээний дараа бүр гарцаа халдвартайжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна;
- 2.14. Амбулаториос тасаг руу хэвтэх эмчлүүлэгч харьяаллын дагуу коронавируст халдвартын шинжилгээний цэгт PCR шинжилээг өгсөн байна;
- 2.15. Төлөвлөгөөт хэвтүүлэн эмчлэх иргэний өвчний карт эсвэл 13А маягтанд хэвтэх өдрийг тэмдэглэж, эмчийн тамгаар баталгаажуулж, PCR шинжилгээг хийлгэх байнгын цэгийн талаарх мэдээллийг өгнө.

3. Хэвтүүлэн эмчлэх иргэдийн дунд хийх халдвартын сэргийлэлтийн арга хэмжээний зураглал

- 3.1. Халдварт голомтлон гарсан бүс, нутагт шаардлага хангасан шинжилгээний хариутай, тархвар зүйн асуумжаар сүүлийн 14 хоногт халдварт голомтлон гарсан

газраар зорчоогүй, зорчсон хүнтэй хавьталгүй, коронавируст халдварын эмнэлзүйн шинж тэмдэггүй иргэнд хэвтүүлэн эмчлэх тасагт нэвтрүүлнэ;

3.2. Хэвтэн эмчлүүлэгчийн сахиур дээрх шалгуурыг хангасан байна;

3.3. Шинжилгээ өгснөөс хойш 72 цагийн дотор PCR шинжилгээний сөрөг хариуг шаардлага хангасан хариу гэнэ; Эмнэлэгт хэвтсэнээс хойш 3-5 дахь хоногт PCR шинжилгээнд хамруулна;

3.4. Хэвтэн эмчлүүлэгчид гаднаас ирэх эргэлтийг зогсоож, сахиурыг солихгүй байна;

3.5. Хэвтэн эмчлүүлж байгаа үйлчлүүлэгчид өдөр бүр эмнэлзүйн шинж тэмдгийн тандалтыг хийнэ;

3.6. Халдварт голомтлон гараагүй бүс, нутагт тархвар зүйн асуумжаар сүүлийн 14 хоногт халдварт голомтлон гарсан газраар зорчоогүй, зорчсон хүнтэй хавьталгүй, коронавируст халдварын эмнэлзүйн шинж тэмдэггүй коронавируст халдварын түргэвчилсэн оношлуураар шинжилгээ хийж сөрөг гарсан иргэнийг хэвтүүлэн эмчлэх тасагт нэвтрүүлнэ;

3.7. Дээрх 3.4, 3.5-д заасан тандалтын арга хэмжээг авна.

4. Тогтмол эмчилгээ, үйлчилгээнд хамрагддаг иргэдийн /гемодиализ, хими, туяа гм/-ийн дунд хийх халдварын сэргийлэлтийн арга хэмжээний зураглал

4.1. Тасаг, нэгжийг аль болох гадагшаа хаалгатай, эмнэлгийн албан хаагч, үйлчлүүлэгчтэй холилдохгүй байхаар зохицуулна;

4.2. Эрсдэл үүссэн нөхцөлд тус тасгийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байхаар зохион байгуулна;

4.3. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг 3 ээлжийн зохион байгуулалтад оруулж, бусад тасгийн үйлчлүүлэгч, эмнэлгийн мэргэжилтнүүдтэй холилдохгүй байх зохион байгуулалтын арга хэмжээг авна;

4.4. Үйлчлүүлэгчид дунд түүврийн аргаар (нэг ээлжинд үйлчлүүлэгч, голомт бүхий бүс нутагт амьдардаг гм) сонгож, PCR шинжилгээ авах арга хэмжээг эмнэлэг зохион байгуулна;

4.5. Үйлчлүүлэгч бүр гараа угаах эсвэл спиртэн суурьтай гар ариутгагчаар ариутгах, бээлийтэй эмчилгээний өрөөнд нэвтэрнэ;

4.6. Эмчилгээ үйлчилгээнд хамрагдах хугацаандаа болон хувцас солих өрөөнд үйлчлүүлэгчид хүн хоорондын зай барих, амны хаалтыг тайлахгүй байх, хоорондоо ярихгүй, хоол унд идэж, уухгүй байх;

4.7. Хувцас солих өрөөнд бөөгнөрөл үүсэхгүй байхад чиглэсэн эмчилгээний эхлэх цагийн зохицуулалтыг хийх;

4.8. Эрүүл мэндийн байгууллагад халдварт тархах нөхцөл байдал үүсэхэд өдөр тутам эмчилгээ хийдэг тасаг, нэгжийн халдварын сэргийлэлтийг нэн тэргүүнд анхаарах, иргэдийн эмчилгээг тасалдуулахгүй байхад чиглэсэн хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах,

5. Эрүүл мэндийн ажилтны дунд хийх халдвартын сэргийлэлтийн арга хэмжээний зураглал

5.1. Эмнэлгийн нийт албан хаагчдын орох гарах урсгалыг үйлчлүүлэгчдээс тусад нь зохион байгуулна,

5.2. Эмнэлгийн мэргэжилтнүүдийг ажлын ачаалал, амралт, ээлжийг зохицуулж, аль болох 24/48-аас ажиллах боломжийг бүрдүүлнэ/эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдээс зөвшөөрөл авч гарын үсэг зуруулан баталгаажуулсан байх/;

5.3. Албан хаагчид амьсгалын замын өвчин, эмгэгийн шинж тэмдэг илрэх, амьдран байгаа газарт сэжигтэй тохиолдол бүртгэгдэх, мөн гэр бүлийн гишүүд сэжигтэй тохиолдлын хавьтал болох, хамгаалалтад авсан газраар зорчсон тохиолдол гарвал ажиллаж байгаа эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэн өөрийгөө ажиглах эсэхийг шийдвэрлүүлнэ;

5.4. Эмнэлэгт суурилсан тандалтыг холбогдох журмын дагуу товлолт хугацаанд хийж, шинжилгээний сорьцыг нийслэл хотод Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн лабораториид, аймгийн эрүүл мэндийн байгууллагууд PCR шинжилгээ хийж байгаа харьяа нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төв, лавлагаа төвд хуваарын өдрөө хүргэнэ;

5.5. Эрүүл мэндийн байгууллага нь ажил, үүргээ гүйцэтгэж байгаа эрүүл мэндийн ажилтны тоон мэдээллийг өдөр бүр гаргаж, эрсдэл үүссэн нөхцөлд хугацаа алдахгүй хариу арга хэмжээ авах бэлэн байдалд байна.

ооОоо